



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/1270

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтад заасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /Ж.Аюуш/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571003772

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч /цаашид “эцсийн өмчлөгч” гэх/-ийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөхөд энэ журмыг баримтална.

1.2.Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд энэ журам хамаарахгүй.

1.3.Эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөхөд Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын холбогдох заалтыг баримтална.

Хоёр.Эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл хүлээн авах

2.1.Улсын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан эрх бүхий этгээдээс гаргасан эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан маягтын дагуу хүлээн авна.

2.2.Энэ журмын 2.1-д заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1.эцсийн өмчлөгч нь гадаадын иргэн бол паспортын хуулбар;

2.2.2.үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий гадаадын хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, түүний албан ёсны орчуулгын баталгаажуулсан хувь.

2.3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээллээ нөхөн бүртгүүлэхэд энэ журмын 2.1-д заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

2.3.1.энэ журмын 2.2-т заасан баримт бичиг;

2.3.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

2.4.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд шинээр бүртгүүлэхэд Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын Зургаа, Долоод, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд мөн журмын Наймд заасан өргөдөлд энэ журмын 2.1-д заасан маягыг тус тус хавсаргана.

Гурав.Эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх

3.1.Улсын бүртгэгч хуулийн этгээдийн дараах эцсийн өмчлөгчийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

3.1.1.тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа этгээд;

3.1.2.энэ журмын 3.1.1-д заасан эцсийн өмчлөгчгүй тохиолдолд дор дурдсан этгээд:

3.1.2.1.хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа;

3.1.2.2.өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа;

3.1.2.3.энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан эцсийн өмчлөгчгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч байгаа.

3.2.Энэ журмын 3.1-д заасан “хөрөнгийн дийлэнх хэсэг” гэж Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан тухайн компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувьцаа, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 4.3-т заасан тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн 33, түүнээс дээш хувь гэж тус тус ойлгоно.

3.3.Энэ журмын 3.1-д заасан эцсийн өмчлөгчийн дараах мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

3.3.1.эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

3.3.2.регистрийн дугаар;

3.3.3.иргэний харьяалал;

3.3.4.эзэмшиж байгаа хувьцааны хувь, хэмжээ.

3.4.Улсын бүртгэгч үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдийн дараах мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

3.4.1.хуулийн этгээдийн нэр;

3.4.2.регистрийн дугаар;

3.4.3.харьяалах улсын нэр;

3.4.4.эзэмшиж байгаа хувьцааны хувь, хэмжээ.

3.5.Энэ журмын 3.4-д заасан үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдийн мэдээллийг энэ журмын 3.1-3.3-т заасан эцсийн өмчлөгч хүнийг бүртгэх хүртэл задална.

**Дөрөв. Эцсийн өмчлөгчийн мэдээлэлд оруулсан
өөрчлөлтийг улсын бүртгэлд хөтлөх**

4.1. Улсын бүртгэгч энэ журмын 3.1-д заасан эцсийн өмчлөгчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын Наймд заасны дагуу бүртгэнэ.

Тав.Бусад

5.1. Хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад мэдүүлж, бүртгүүлнэ.

5.2. Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу гаргаж өгнө.

---oOo---